



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/31

Мөрөн сум

Бэлчээрийн худаг гаргах ажлын явцад
хяналт тавих, хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2025 оны 03 сарын 27-ний өдрийн А/56 тоот захирамраар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2025 оны 05 сарын 02-ний өдрийн 8 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. “ЭХНИЙ ЭХЭН”-ХХК нь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих “Зөөлөн” багийн нутаг “Цагаан толгойн ар” гэдэг газар “БЭЛЧЭЭРИЙН ХУДАГ” гаргах ажлын тендерт ялж 2025 оны 06 сарын 01-ны өдрөөс 2025 оны 07 сарын 01-ний дотор хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан тул уг ажлын явцад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулах, хүлээн авах сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: С.Сүхчулуун Зөөлөн багийн Засаг дарга

Гишүүдэд: Ш.Баасандорж Байгаль орчны хяналтын улсын байцаагч
А.Энхтөр Нярав

2. “ЭХНИЙ ЭХЭН”-ХХК хүлээн авах “БЭЛЧЭЭРИЙН ХУДАГ”- гаргах ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтийг үндэслэн тоо хэмжээ, хүчин чадал, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга С.Сүхчулуун-д үүрэг бологсугай

3. “БЭЛЧЭЭРИЙН ХУДАГ”-ийг Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэж авахын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д даалгасугай.

4. “Зөөлөн” багийн нутаг “Цагаан толгойн ар” гэдэг газарт шинээр гаргасан “бэлчээрийн худаг”-ийг багийнхаа нэг малчин өрхөд гэрээгээр эзэмшүүлж ашиглалт, хадгалалтанд нь байнгын хяналт тавиж ажиллахыг “Зөөлөн” багийн Засаг дарга С.Сүхчулуун-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ